



## БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ, ЗАСАГЛАЛЫН УЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Огноо (он, сар, өдөр):	2024.03.25
Үнэт цаас гаргагчийн нэр:	Төрийн банк ХК
Үнэт цаасны нэр, код (МХБ симбол):	SBM
Салбарын ангилал:	Санхүү
Тайланд орсон компаниуд (энэхүү тайланд орсон толгой болон охин компаниудын мэдээлэл):	Төрийн банк ХК
Тайлангийн хамрах хугацаа:	2023.01.01 - 2023.12.31
Тайланг баталгаажуулсан гүйцэтгэх удирдлагын мэдээлэл (нэр, албан тушаал):	Өлзий овогтой Гантер
Гүйцэтгэх удирдлагын гарын үсэг:	Төрийн Банкны Гүйцэтгэх захирал ТӨРИЙН БАНК
Хариуцсан албан тушаалтны овог нэр, албан тушаал, холбоо барих имэйл хаяг, утас:	Алтантүрэл овогтой Энх ардэнэ 1341409 1C13380 Тогтвортэй хөгжлийн албаны менежер, <a href="mailto:enkherdene.a@statebank.mn">enkherdene.a@statebank.mn</a> , 99102395

Код	Бүлэг	Шалгуур үзүүлэлт	Үзүүлэлт 2022 он	Үзүүлэлт 2023 он	Хэмжих нэгж	Нэмэлт мэдээлэл	Тайлбар	Холбоос
MS	<b>Тогтвортой хөгжлийн удирдлагын системтэй холбоотой шалгуур үзүүлэлтүүд</b>							
MS1.1	Тогтвортой хөгжлийн удирдлагын систем	Удирдлагын амлалт	Удирдлагаас баталсан тогтвортой хөгжлийн амлалт/мэдэгдэл байдаг эсэх	1. Тийм	1. Тийм	Төрийн банкны "Байгаль орчин, нийгэм, засаглалын бодлого"-д 2030 онд ногоон зээлийн багцыг нийт зээлийн багцын 10%-д хүргэх зорилт дэвшүүлэн ажиллаж байна.  Мөн UN Global compact буюу Даян дэлхийн гэрээнд нэгдэн 4 булэгт 10 зарчмыг дагаж мөрдөн ажиллаж байна.  Түүнчлэн ТоC холбооны гишүүн байгууллага болсноор ТоC-ын 8 зарчмыг хэрэгжүүлэн ажиллаж байна.		GRI 102
MS2.1		Тогтвортой хөгжлийн бодлого, зохицуулалт	Тогтвортой хөгжлийн бодлого, зорилтуудыг тодорхойлж баталсан эсэх	1. Тийм	1. Тийм	Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоолоор "Байгаль орчин, нийгэм, засаглалын бодлого"-ыг 2022 онд шинэчлэн батлуулж, банкны сайтад байршиулсан, 2023 онд нэмэлт, өөрчлөлт оруулсан. <u>Бодлогын линк</u>		GRI 103, ISO 14001
MS2.2		Бүтэц удирдлага	Танай компани тогтвортой хөгжлийн асуудал хариуцсан хороо байдаг эсэх	2. Үгүй	1. Тийм	Тогтвортой хөгжлийн хороо 2023 онд шинээр байгуулагдсан, нийт 5 гишүүдтэй, жендэрийн харьцаа 60:40 (эр/эм).		GRI 103, ISO 14001
MS3.1			ТҮЗ-ийн түвшинд тогтвортой хөгжил / БОНЗ-ын асуудал хариуцсан гишүүн (бүтэн цагийн/хавсрлан) байдаг эсэх	2. Үгүй	1. Тийм	"Төрийн банк" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороодын ажиллах журам" -ыг ТҮЗ-ийн 2023 оны 13 дугаар тогтоолын хавсралтаар шинэчлэн баталж, журмын дагуу Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэд Эрсдэлийн удирдлагын хороо ажиллахаар тогтсон. Эрсдэлийн удирдлагын хорооны эрхлэх асуудлын хүрээнд банкны үйл ажиллагаанд байгаль орчин, нийгмийн хариуцлага, эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэл байгаа эсэхийг үнэлэх тогтолцоог бүрдүүлэх, эрсдэлийг удирдах асуудал хамаарч байна. БОНЗ-ын асуудлыг ТҮЗ-ийн 3 гишүүн хариуцан ажиллаж байна.		GRI 102

MS3.2		Гүйцэтгэх удирдлагын түвшинд тогтвортой хөгжил/ БОНЗ-ын асуудал хариуцсан албан тушаалтан (бүтэн цагийн/хавсрлан) байдаг эсэх	1. Тийм	1. Тийм		Тогтвортой хөгжлийн хорооны даргаар Тэргүүн дэд захирал, Тогтвортой хөгжлийн ажлын хэсгийн ахлагчаар Дэд захирал тус тус ажилладаг.  Мөн Гүйцэтгэх Захирлын шууд удирдлага дор Тогтвортой хөгжлийн алба үйл ажиллагаа явуулдаг.		GRI 102
MS3.3		Үйл ажиллагааны түвшинд тогтвортой хөгжил/ БОНЗ-ын асуудал хариуцсан албан тушаалтан (бүтэн цагийн/хавсрлан) байдаг эсэх	1. Тийм	1. Тийм		Төрийн банк 2023 онд шинээр Тогтвортой хөгжлийн албыг байгуулсан бөгөөд менежер, ТоС хариуцсан мэргэжилтэн 2, байгаль орчин, нийгмийн үнэлгээний 1 орон тоотойгоор ажиллаж байна. Мөн холбогдох газар, хэлтсүүдийн төлөөллөөс бүрдсэн "Тогтвортой хөгжлийн ажлын хэсэг" ажиллаж байна. Ажлын хэсгийг Дэд захирал удирддаг.		GRI 102
MS3.4		Танай компани ТУЗ-ийн хурлын хөтөлбөрт тогтвортой хөгжлийн асуудлыг албан ёсоор тусгадаг уу?	1. Тийм	1. Тийм		Төрийн банкны Эрсдэлийн удирдлагын хорооны эрхлэх асуудлын хүрээнд байгаль орчин, нийгэм засаггалын холбогдох асуудлыг тухай бүр хэлэлтидэг.		GRI 102
MS3.5	Тогтвортой байдлын нөлөөллийн үнэлгээ	Танай компани эдийн засаг, байгаль орчин, нийгэмд үзүүлэх сэргэ нөлөөллөөс хэрхэн зайлсхийх, бууруулах, арилгах, зөрэг үр нөлөөг сайжруулах талаар тайлбарласан нөлөөллийн үнэлгээ эсвэл матриц байдаг эсэх	1. Тийм	1. Тийм		Төрийн банкны БОНЗ-ын бодлого болон Тогтвортой хөгжлийн журамд тус тус тусган хэрэгжүүлэн ажиллаж байна.		SASB
MS4.1	Чадавх бүрдүүлэлт	Нэг ажилтанд ногдох тогтвортой хөгжлийн тухай сургалтын жилийн дундаж цаг, хүйсээр	0.5	9.28	цаг	Тогтвортой хөгжил, Байгаль орчин, нийгэм, засаглалын чиглэлээр 2023 онд ажилтнуудаа мэргэшүүлэх, чадавхжуулах, мэдлэг олгох нийт 30 удаагийн сургалт зохион байгуулдаж нийт 1'809 ажилтан хамрагдсан. Сургалтад хамрагдсан удирдах		GRI 102

					ажилтнуудын 40% нь эрэгтэй, 60% эмэгтэй, ажилтнуудын 13% нь эрэгтэй, 87% нь эмэгтэй байна.		
MS4.2	Хяналт	Тогтвортой байдлын асуудал нь аудитын хорооны ўйл ажиллагаа, дотоод хяналтын чиг үүрэгт хамаардаг уу?	1. Тийм	1. Тийм	Холбогдох чиг үүрэгт хамаарч байна.		GRI 102, SDG 12
MS4.3	Тогтвортой байдлын тайлagnal	Танай компани тогтвортой байдал/ хөгжлийн тайлан (жилийн тайланд нэгтгэдэг эсвэл тусдаа тайлан)-гаа жил нэгээс доошгүй удаа тайлagnадаг уу?	1. Тийм	1. Тийм	Тогтвортой хөгжлийн жилийн тайланг 2023 оноос анх удаа тусад нь тайлagnаж эхэлсэн. <u>Жилийн тайлангийн линк</u>		GRI 102, SDG 12
MS5.1		Танай компани олон улсын уур амьсгалын эрдээлийн стандартын дагуу тайлagnадаг уу?	2. Үгүй	2. Үгүй	-	Цаашид судалж хэрэгжүүлнэ.	GRI 102, SDG 12
MS5.2	Гишүүнчлэл, хамтын ажиллагаа	Тогтвортой хөгжлийн болон БОНЗ-ын мэдээллийг хэндлөнгийн байгууллагаар баталгаажуулдаг.	2. Үгүй	2. Үгүй	-	Цаашид судалж хэрэгжүүлнэ.	GRI 102, SDG 17
MS5.3		Танай компани тогтвортой хөгжлийн чиглэлээр ўйл ажиллагаа явуулдаг олон улсын болон дотоодын холбоо, нэгдэлтэй нэгдэж хамтран ажилладаг уу?	1. Тийм	1. Тийм	1. Монгол улсын Тогтвортой санхүүгийн холбооны гишүүн байгууллага /2017 оноос/ 2. НҮБ-ын Даян дэлхийн гэрээ-UN Global compact /2023 оноос/ 3. PCAF-Нүүрстөтөрөгчийн нягтлан бодох бүртгэлийн санхүүгийн түншлэл байгууллага /2023 оноос/		GRI 102, SDG 17

							4. Монголын хог хаягдлыг дахин боловсруулах үндэсний холбоо /2023 оноос/		
MS6.1	<b>Байгаль орчны шалгуур үзүүлэлтүүд</b>								
E1.1	Эрчим хүч	Нийт эрчим хүчиний хэрэглээ	Эрчим хүчиний нийт зарцуулалтын хэмжээ болон зардал	1,113,907 211'955.96	1,266,991 463'419.78	kВт.ц, мян. төгрөг	<p>Цахилгааны зарцуулалтыг банкны төвийн 3 оффисын 6,414.43 м.кв талбай бүхий барилгын хувьд гаргасан. Эрчим хүчиний эх үүсвэр нь УБЦТС, нэмэлтээр эрчим хүч тасарсан тохиолдолд генератор ажиллуулдаг.</p> <p>2022 онд 211'955.96 мянган төгрөг, 2023 онд эрчим хүчиний тариф нэмэгдсэнтэй холбоотой 463'419.78 мянган төгрөгийн зардал гарсан.</p>		GRI 302, SDG 12
E1.2		Цахилгаан	Цахилгааны нийт зарцуулалтын хэмжээ болон хэмнэлт (жилээр)	1,113,907	1,266,991	kВт.ц '000	<p>Банкны төвийн 3 оффисын 6,414.43 м.кв талбай бүхий барилгын цахилгааны нийт хэрэглээ 2023 онд 1,266.9 Mega Втц байна. Төв 1-р байрны дулаан алдагдал өндөр байсан тул цахилгааны хэрэглээ өндөр гарсан. Дата төвийн тоноглолтой нэмэгдсэн. Цаашид цонхнууд шинэчлэх, дулаан алдагдлыг хэмжүүлж, бууруулах арга хэмжээ 2024 онд авч ажиллахаар байна.</p> <p>Хэмнэлт бий болгосон ажлуудаас дурьдвал:</p> <p>*Цахилгаан хэрэгслийдийг эрчим хүчиний хэмнэлттэй А+ болон түүнээс дээш хэмнэлтийн үзүүлэлттэй тоног төхөөрөмжүүдийг сонгодог болсон.</p> <p>* Төв байруудын гэрлийг лэд гэрлээр сольсон.</p> <p>* Компьютер, тоног төхөөрөмжүүдийг ашиглаагүй тохиолдолд автоматаар амралтын горимд шилжүүлэх тохиргоо хийгдсэн.</p> <p>* Ажилтнуудын дундын принтер, цайны цагаар гэрлээ унтраах г.м. ажлууд хэвшил болсон.</p>		GRI 302, SDG 12

E1.3	Дулаан	Дулааны нийт зарцуулалтын хэмжээ болон хэмнэлт (жилээр)	3,305	3,800	BTU & % Гкал	Банкны 6,414.43 м.кв талбай бүхий төвийн 3 оффисын барилгын дулааны нийт хэрэглээ 2023 онд 3,800 Гкал байна. Дулаан алдагдал их байсантай холбоотой ёссэн.  Дулаанаа хадгалах зорилгоор Тав оффисын барилгын шилэн фасадтай хананы дотор талыг дулаалтын эсгий хавтангаар бүрсэн, мөн дулааны температурыг гадна агаарын градусаас хамааран тохируулгаар буюу гараар багасган хэмнэлт хийн ажиллаж байна.	-	GRI 302, SDG 12	
E1.4	Түлш	Түлшний нийт зарцуулалтын хэмжээ болон хэмнэлт (жилээр)	42,710.97	78,658.91	Литр/кг & %, ГЖоуль, Төгрөг	Банкны төвийн 3 оффисын түлш, шатахууны нийт хэрэглээ 2023 онд 78'658.91 л байна. Түлшний зарцуулалтыг бууруулах зорилгоор жижиг суудлын болон хайбрид мотортой автомашиныг үйлчилгээнд ашиглаж байна.  2023 онд бизнесийн үйл ажиллагаа өргөжсөнтэй холбоотой 195.1 сая төгрөгийн түлшний зардал гарсан байна.	-	GRI 302, SDG 12	
E1.5	Хүрэн эрчим хүч	СЭХ-ээс бусад эх үүсвэрээс авсан эрчим хүчиний хэрэглээний хувь	100%	100%	%	Нүүрс		SFRD	
E1.6	Сэргээгдэх эрчим хүч	СЭХ үүсвэрээс гаргаж авсан эрчим хүчиний хэрэглээний хувь	-	-	0%	-		GRI 302, SDG 7	
E2.1	Хүлэмжийн хийн ялгарал	3.1 Хүлэмжийн хийн ялгаруулалт	Компанийн шууд ба шууд бус үйл ажиллагаанаас ялгарсан нийт хүлэмжийн хийн дүн	11,843.2	12,422.5	CO2/тонн	Банкны ялгаруулж буй хүлэмжийн хийг Scope 1 ба Scope 2-ын хурээнд 2022 оны хувьд зөвлөх үйлчилгээ авч тоопуулсан. 2023 оны хувьд дотоодын болон олон улсын аргачлалыг ашиглаж тооцоолов. /ISO 14064-1:2018, ХХЯ-ын нягтлан бодох бүтгэлийн олон улсын тайлагналын стандарт, Эрчим хүчиний салбарын хүлэмжийн хийн ялгарлыг хэмжих, тайлагнах, баталгаажуулах аргачлал (ЭХЗХ)/		GRI 305, SDG 13, WRI/WBCSD GHG protocol.

E2.2		3.2 Бууруулсан хүлэмжийн хий	Байгууллагын шууд ба шууд бус үйл ажиллагаанаас ялгарсан хүлэмжийн хийн нийт дүн (жилээр)	-	-	CO2/тонн	-	Цаашид хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах төлөвлөгөө гарган ажиллахаар байна.	GRI 305, SDG 13, WRI/WBCSD GHG protocol.
E2.3		3.3 Дүйцүүлэх арга хэмжээ /Карбон оффсет/	Нийт карбон оффсет буюу дүйцүүлэх арга хэмжээны (мод тарих хетөлбэр, эсвэл хүлэмжийн хийг бууруулах гадны теслийг дэмжих гэх мэт)бууралт	30	63.8	CO2/тонн	Банкны нийт карбон оффсет буюу мод тарих арга хэмжээний хүрээнд 63.8 тн/CO2-той тэнцэх хүлэмжийн хийг бууруулсан байна.  Мөн Тэрбум мод сантай хамтран ажиллаж сар бүр гүйлгээний шимтгэлээс тодорхой хувийг 2022 оны 5-р сараас хойш тогтмол төвлөрүүлснээр Төрийн банкны хувьд 16'800 мод тарих, 11.4 га талбайд ойжуулалт хийх, 5575 хүүхдэд ногоон орчин бүрдүүлэх зэрэг үйлсэд хувь нэмрээ оруулсан байна.	-	GRI 305, SDG 13, WRI/WBCSD GHG protocol.
E3.1	Уур амьсгалын вөрчлөлт	Уур амьсгалын бодлого, журам	Танай компани уур амьсгалын вөрчлөлтийн эсрэг тусдаа эсвэл бусад журамд тусгасан бодлоготой юу?	2. Үгүй	2. Үгүй	-		Цаашид судалж хэрэгжүүлнэ.	GRI 201, TCFD, SDG 13
E3.2		Уур амьсгалын эрдэл ба боломжийн үнэлгээ	Танай компани уур амьсгалын эрсдэл, боломжийн талаарх үнэлгээ хийсэн үү?(сценариийн шинжилгээ, стресс тест гах мат)	2. Үгүй	2. Үгүй	-		Цаашид судалж хэрэгжүүлнэ.	GRI 201, TCFD, SDG 13
E3.3		Эдийн засгийн хохирол	Уур амьсгалын вөрчлөлтөөс үүдэлтэй гамшиг, үйл явдлын улмаас учирсан эдийн засгийн нийт хохирлын хэмжээ	-	-	0 Төгрөг	-	Тайлант хугацаанд энэ төрлийн хохирол учраагүй.	GRI 201, TCFD, SDG 13

E3.4		Уур амьсгалын хөрөнгө оруулалт	Уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг дэд бүтэц, дасан зохицол, бүтээгдэхүүн хөлжилд оруулсан нийт хөрөнгө оруулалтын дүн	-	-	0 Төгрөг	-	-	GRI 201, TCFD, SDG 13
E3.5		Уур амьсгалын өөрчлөлтөөс урьдчилан сэргийлэх зсвэл дасан зохицох	Уур амьсгалын өөрчлөлтэй холбоотойгоор танай компанийн ашигт ажиллагаа зсвэл бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарт нөлөөлэх эрдэлээс урьдчилан сэргийлэх, (хэрэв урьдчилан сэргийлэх боломжгүй бол) дасан зохицох чиглэлд хэрэгжүүлэх арга хэмжээ/алхмуудыг тодорхойлсон уу?	2. Үгүй	2. Үгүй	-	-	-	Цаашид судалж хэрэгжүүлнэ.
E4.1	Ус	Усны хэрэглээ	Ашигласан усны нийт хэмжээ	2,770	4,000	м3/Л	Банкны төвийн 3 оффист 2023 онд 4,000 м3/Л ус хэрэглэсэн.	-	GRI 303, SDG 6
E4.2		Хэмнэсэн ус	Хэмнэлт, үр ашгийг дээшлүүлснээр нийт хэмнэсэн/дахин боловсруулсан усны хэмжээ	-	-	м3/Л	Төвийн байруудад бүх 00 өрөөний холигч крантны цоргонуудад нэмэлтээр ус хэмнэгч цорго байрлуулах, суултуурын бочкины дотор усны саванд ус дүүргэж хийх зэрэг ажлуудыг зохион байгуулж байна.	Цаашид судалж хэрэгжүүлнэ.	GRI 303, SDG 6
E4.3		Дахин боловсруулсан ус	Дахин ашигласан болонболовсруулс ан усны эзлэх хувь	-	-	0%	-	-	Цаашид судалж хэрэгжүүлнэ.
E4.4		Хаягдал бохир ус цэвэрлэх	Цэвэрлэсэн нийт хаягдал бохир усны хэмжээ	2,770	4,000	м3/Л	Төв цэвэрлэх байгууламж руу нийлүүлдэг.	-	GRI 303, SDG 6

E5.1		Хог хаягдал	Нийт ялгаруулсан хог хаягдлын хэмжээ	-	23	тонн	Төрийн банк 2023 онд Монголын хог хаягдлыг дахин боловсруулах холбоонд гишүүнээр элсэж 5 модуль сургалтыг ажилтнууддаа авч, сэтгүүлд мэдээлэл гаргасан. Мөн ажилтан бүрт зориулсан хогийн савыг нэгдсэн байдлаар хураан авч, Төв оффисын давхар бүрт ангилдаг хогийн савыг байрлуулан ангилан ялгаж, тушаан ажиллаж байна.	-	GRI 306, SDG 12	
E5.2		Хатуу хог хаягдал	Дахин боловсруулсан хатуу хог хаягдал	Хог хаягдлыг дахин боловсруулсан хувь	-	10	%	2023 онд нийт 4 удаа 120 кг ус, ундааны хуванцар сав цуглувж дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлсэн.  Хог хаягдал тээвэрлэлтийн гэрээний дагуу өдөр бүр ачуулдаг. Терлийн хувьд дахин боловсруулах боломжтой цаасны хог ихэвчлэн гардаг.	2024 онд Төв 1,2,3 байруудад зориулалтын цэг бэлдэж дахин боловсруулах хог хаягдлыг тушаах ажиллаж байна.	GRI 306, SDG 12
E5.3		Хортой хог хаягдал	Хортой хаягдлын хэмжээ цахилгаан хэрэгслийн орно)	(Үүнд хог нийт)	8	10.5	тонн	Төв 1-р байранд эмч ажиллаж байгаатай холбоотой 7 хоног бүр 0.5 -1 кг аюултай хог хаягдал гардаг ба гэрээт байгууллагад егч устгуулдаг. Жилд дунджаар 50 кг орчим зүү тариурын аюултай хог хаягдал ялгаруулж байгааг зохих журмын дагуу устгал хийж байна. Төв банкны агуулахад хадгалж байгаа эвдэрч, актлэгдсан цахилгаан хэрэгсэл, тоног төхөөрөмжийг жилд 2 удаа нийт 10 орчим тонн орчим хог хаягдлыг ачуулж устгалд оруулдаг.	Төрийн банк нь 2024 оны хорт хог хаягдал болох цахилгаан хэрэгсэл, хуурай баттерей болон хар тугалын аккумуляторыг дахин боловсруулах байгууллагад нийлүүлэхээр судалж байна.	GRI 306, SDG 12
E6.1	Биологийн олон янз байдал	Ногоон байгууламж, төлөвлөлт	Байгаль орчны хувьд тогтвортой ашиглаж буй нийтийн эзэмшлийн талбай буюу барьсан ногоон байгууламжийн	-	-	-	Тэрбум мод сантай хамтран ажилласнаар 6'075 мкв ногоон байгууламжийг байгуулаад байна.	Банкны төвийн 3 байрны хувьд ногоон байгууламж	GRI 304, SDG 15	

			талбайн нийт талбайд эзлэх хувь					байхгүй болно.	
E6.2		Зэрлэг ургамал, амьтдыг хамгаалах	Хамгаалсан төрөл зүйлийн тоо	8	8	Төрөл зүйлийн тоо - 8	Эко картын бүтээгдэхүүний хүрээнд Хүрээлэн төсөлтэй хамтран мазаалай, цоохор ирвэс, цэн тогоруу, мануул, бүргэд, буга, тахь болон чоно гэсэн 8 төрөл зүйлийн амьтдыг хамгаалах үйлсэд хувь нэмрээ оруулж байна.		GRI 304, SDG 15
E6.3		Биологийн олон янз байдалд сэргээр нөлөөлж буй үйл ажиллагаа	Тусгай хамгаалалттай газар нутаг, биологийн олон янз байдал, соёлын үнэ цэнэ өндөртэй газар нутгийг эзэмшиж, түрээсэлсэн, удирдаж байгаа эсвэл зэргэлдээх үйл ажиллагааны талбайн нийт талбайд эзлэх хувь	-	-	%	-	Байхгүй	SFRD, IFC Performance Standard 6
S	<b>Нийгмийн шалгуур үзүүлэлтүүд</b>								
S1.1	Хүний нөөц	Хүний нөөцийн тогтвортой байдал	Үндсэн ажилтнуудын ажлын байрны сэлгээний хувь (тухайн онд ажлаасаа гарсан ажилтнуудын тоог ажилласан ажилтнуудын дундаж тоонд хуваах)	21%	20.5%	%	Нийт ажилласан дундаж ажилтны тоо 3336, ажлаас гарсан ажилтны тоо 684.		GRI 401, SDG 8
S1.2		Шинээр бий болгосон ажлын байр	Өмнөх оны мөн үеэс нэмэгдсэн бүтэн цагийн ажлын байрны тоо	30	49	Тоо	Банк нээлттэй хувьцаат компани болсонтой холбогдуулан бизнесийн зорилго, зорилтыг хэрэгжүүлэхтэй холбоотой Бизнесийн хамтын ажиллагааны алба, Тогтвортой хөгжлийн алба болон Засаглалын албыг үүсгэн байгуулсан. Тус бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлт болон батлагдсан орон тоонд багтаан чиг үүрэг, орон тоог зохистой хуваарилах замаар тус онд шинээр		GRI 401, SDG 8

							нийт 49 ажлын байрыг нэмэгдүүлсэн нь өмнөх оноос 19-өөр нэмэгдсэн.		
S1.3		Сургалт	Нэг ажилтанд ногдох дундаж сургалтын цаг	4	3	хүн цаг	2023 оны хэмжээнд нийт 173 сургалт зохион байгуулагдан давхардсан тоогоор 11'023 ажилтнуудыг (Төв банк 851, УБ хот 4990, ОН 5182) танхим болон цахим хэлбэрээр хамруулсан. Нийт 33'211 цагийн сургалт, нэг ажилтанд ногдох жилийн дундаж сургалт 3 хүн цаг байна. 2022 онтой харьцуулахад давхардсан тоогоор сургалтад хамрагдсан ажилtnы тоо буурсантай холбоотойгоор дагалдах хүн цаг буурсан байна.		GRI 401, SDG 8
S2.1	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй (ХАБЭА)	ХАБЭА-н бодлого	ХАБЭА-н бодлого, журам бий юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэсэн)?	1. Тийм	1. Тийм		2023 онд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн журмыг тусад нь батлуулсан.		GRI 103, SDG 10
S2.2		Осол аваар	Үйл ажиллагааны явцад гарсан осол аваарын хувь	0%	0.14%	%	2023 онд 5 хүн үйлдвэрлэлийн осолд өртөж, ослын акт гарсан. ХАБЭА ISO:45001-2018 стандартыг 2024 онд хэрэгжүүлэхээр ажиллаж байна.		GRI 403. SDG 3
S2.3		ХАБЭА-н сургалт	Жилд нэг ажилтанд ногдох дундаж ХАБЭА сургалтын цаг	0.08	15	цаг	Нэг ажилтанд ногдох ХАБЭА сургалт жилд 15 цаг байна.		GRI 403. SDG 3
S2.4		Эрүүл мэндийн хөтөлбөр	Эрүүл мэндийн үзлэг зэрэг сайн дурын эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдсан ажилчдын тоо, жилээр	2,849	2,787	хүн	Ажилтнуудын эрүүл мэндийг хамгаалах зорилгоор улсын томоохон эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагуудыг судалж багц үүсгэн, ажилтны сонгосон багцаар эрүүл мэндийг урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамруулж байна.  Мөн ажилтнуудын эрүүл мэндийн асуудалд тогтмол анхаарах зорилгоор эмчийг үндсэн орон тоогоор ажиллуулж байна.		GRI 403. SDG 3
S3.1	Эрх тэгш байдал	Жендерийн бодлого, журам	Жендерийн бодлого, журам бий юу (тусдаа бодлого журам эсвэл аль	1. Тийм	1. Тийм		Банкны "Байгаль, орчин нийгмийн засаглалын бодлого" болон "Тогтвортой хөгжлийн журам"-д банк үйл ажиллагаа болон харилцагчдад зориулсан бүтээгдэхүүн		GRI 405, SDG 5

		нэг журамд нэгтгэсэн)?				үйлчилгээ, харилцаа хамтын ажиллагаандaa жендерийн эрх тэгш байдлыг баримтлан ажиллах зарчим, хэрэгжүүлэх үйл ажиллагааг тус тус тусган баталсан. <a href="#">Бодлогын линк</a>		
S3.2		Ажлын байрны бэлгийн дарамтын эсрэг бодлого, журам	Бэлгийн дарамтын эсрэг бодлого, журам бий юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэсэн)?	1. Тийм	1. Тийм	Банкны Хөдөлмөрийн дотоод журмын хөдөлмөр эрхлэтийн харилцаанд баримтлах зарчим, ажилтны эрх үүрэг, хориглох зүйл, ноцтой зөрчил гэсэн зүйлүүдэд жендер, бэлгийн дарамтын эсрэг арга хэмжээний заалтууд тусгагдсан.		GRI 103, SDG 5
S3.3		Ялгаварлан гадуурхалтын эсрэг бодлого, журам	Ялгаварлан гадуурхалтын эсрэг бодлого, журам бий юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэсэн)?	1. Тийм	1. Тийм	Банкны Хүний нөөцийн бодлого, Хөдөлмөрийн дотоод журмаар ажилтныг ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, нийгмийн болон гэрлэлтийн байдал, хөрөнгө чинээ, шашин шүтлэг, үзэл бодол, улс төрийн үзэл бодол, үйлдвэрчний эвлэлийн гишүүн эсэх, эрүүл мэндийн байдал, жирэмсэн болон амаржсан эсэх, бэлгийн болон хүйсийн чиг баримжаа, илэрхийлэл, хөгжлийн бэрхшээл, гадаад төрхеөр нь шууд, эсхүл шууд бусаар ялгаварлан гадуурхах, эрхийг нь хязгаарлах, давуу байдал олгохыг тус тус хориглосон байдал.		GRI 103,SDG 10
S3.4		Ажилтнуудын хүйсийн харьцаа	Нийт үндсэн ажилтнуудын тоонд эрэгтэй, эмэгтэй ажилтны эзлэх хувь	73% эм, 27% эр	73% эм, 27% эр	%	-	GRI 405, SDG 5
S3.5		Үдирадах зэвлэлийн хүйсийн харьцаа	Үдирадах зэвлэлийн гишүүдийн эрэгтэй, эмэгтэй хүйсийн харьцаа	40% эм, 60% эр	37.5% эм, 62.5% эр	%	-	GRI 405, SDG 5
S3.6		Гүйцэтгэх удирдлагын хүйсийн харьцаа	Гүйцэтгэх удирдлагын түвшний ажилтнуудын эрэгтэй, эмэгтэй хүйсийн харьцаа	28.5% эм, 71.5% эр	28.5% эм, 71.5% эр	%	-	GRI 405, SDG 5

S3.7		Дунд болон анхан шатны нэгжийн ажилтнуудын хүйсийн харьцаа	Дунд болон анхан шатны нэгжийн ажилтнуудын эрэгтэй, эмэгтэй хүйсийн харьцаа	73% эм, 27% -эр	74.7% эм, 25.3% -эр	%	-		GRI 405, SDG 5
S3.8		Жендерт суурилсан цалингийн зөрүү	Эрэгтэй ба эмэгтэй ажилтнуудын дундаж цалингийн харьцаа	1:1	1:1	Харьцаа	Эрэгтэй ба эмэгтэй ажилтнуудын дундаж цалингийн харьцаа тэнцүү.		GRI 405, SDG 5, SFRD
S4.1	Хуртэмжтэй байдал	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бодлого, журам	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан бодлого, журам бий юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэсэн)?	1. Тийм	1. Тийм		Хөдөлмөрийн дотоод журмын 6.1; 10.2.17; 19.3; 27.1.18;-д тусгасан.		SDG 10
S4.2		Хөгжлийн бэрхшээлтэй ажилтнууд	Хөгжлийн бэрхшээлтэй ажилтнуудын нийт ажилтны тоонд эзлэх хувь	2.0%	2.1%	%	Хөгжлийн бэрхшээлтэй нийт 84 ажилтан байна.		SDG 10
S4.3		Оффисын хуртэмж	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хуртэмжтэй байдлаар шийдсэн оффис, байгууламжтай юу	1. Тийм	1. Тийм		Улаанбаатар болон Орон нутгийн нийт 496 нэгжээс 312 нэгж суугаа барьертай 48 нэгж хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан тэмдэглэгээ бүхий автомашины зогсоолтой, 175 нэгж налуу замтай, 38 нэгж хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан ариун цэврийн өрөөтэй, 45 нэгж тэргэнцэртэй иргэдэд зориулсан хонх байршуулан ажиллаж байна.		SDG 10
S4.4		Торгууль	Байгаль орчны зөвшөөрөл, стандарт, дүрэм журмыг дагаж мөрдөөгүйгээс гарсан зөрчлийн тоо	-	-	Төгрөг	Зөрчил байхгүй.		SDG 10

S5.1	Нийгмийн хариуцлага ба ил тод байдал	Оролцогч талуудын оролцооны засаглал	Оролцогч талуудтай хамтарч ажиллах талаар тусгайлсан бодлого байгаа юу?	2. Үгүй	1. Тийм		"Төрийн банк" ХК-ийн Төлөөлен удирдах зөвлөлийн 2023 оны 24 дүгээр тогтоолын хавсралтаар "Оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах бодлого" батлагдаж, "Төрийн банк" ХК-ийн оролцогч талууд болон ирээдүйн хөрөнгө оруулагч, санхүүгийн зах зээлд оролцогч этгээдэд банкны үйл ажиллагааны мэдээлэл, стратегийн зорилтын хэрэгжилт, засаглал, хэтийн төлөв, санхүүгийн гүйцэтгэл, үйл ажиллагаанд нөлөөлж болохуйц үйл явдлын талаарх мэдээллийг хүргэж, хамтран ажиллах бодлогыг тодорхойлсон.  <u><a href="#">Бодлогын линк</a></u>	-	IFC
S5.2		Нийгмийн нөлөөллийн үзүүлэлтэй, газар чөлөөлөлтийн бодлого журам	Танай компани нийгэмд нөлөөлөх байдлын бодлого, журамтай юу? (Үүнд газар чөлөөлөлт багтана)	2. Үгүй	2. Үгүй	-		Байхгүй.	IFC Performance Standards
S5.3		Санал гомдолыг шийдвэрлэх бодлого/журам	Гомдол маргааныг шийдвэрлэх бодлого, механизмыг бий юу?	1. Тийм	1. Тийм		Харилцагчаас ирсэн санал гомдолыг "Харилцагчийн мэдээллийн төвийн үйл ажиллагааны журам", Ажилтны хувьд "Төрийн банкны ажилтнаас гаргасан өргөдөл гомдолыг хүлээн авах, шийдвэрлэх тухай журам"-аар зохицуулдаг.		GRI 102, SDG 16
S5.4		Олон нийтэд ил тод мэдээлэх	Танай компанийн үйл ажиллагаа нөлөөлж буй иргээдэд мэдээлэл өгөх, санал хүсэлт авч, гомдол шийдвэрлэх тогтолцоо бий юу?	1. Тийм	1. Тийм		Харилцагчаас санал, хүсэлт, гомдсл хүлээн авч журмын дагуу холбогдох газар, хэлтэс, алба, салбар, нэгжүү илгээн шийдвэрлүүлж, харилцагчид хариу өгсөн эсэхэд хяналт тавьж ажилладаг.  1. Лавлах утас: 1800-1881 2. Онлайн туслах: <a href="#">Линк</a> 3. Харилцагчийн санал хүсэлтийн булан: <a href="#">Линк</a> 4. Facebook chat: <a href="#">Линк</a> 5. Цахим шуудан: contact@statebank.mn		IFC Performance Standards

S5.5		Ажилчид/олон нийтийн санал гомдол	Ажилчид болон олон нийтээс ирсэн санал гомдлыг шийдэрлэсэн хувь	99.99%	99.96%	%	Санал гомдлыг 99.96% шийдвэрлэсэн.		GRI 413, SDG 8
S5.6		Нийгмийн хариуцлагын үйл ажиллагаанд зарцуулсан хөрөнгө оруулалт	Нийгмийн хариуцлагын арга хэмжээ, хөтөлбөрт зарцуулсан хөрөнгө оруулалтын нийт орлогод эзлэх хувь	0.04	0.05	%	<p>1. Байгальд ээлтэй Гялс цэвэрлэгээ-2023 аяныг 2023.05.06-ны өдөр Монгол орон даяар 21 аймгийн 315 сумд Төрийн банкны нийт ажилтнууд Гялс цэвэрлэгээг зохион байгуулсан. Аяны хүрээнд нийт 7,440 га талбайг цэвэрлэж, 800 тонн буюу нийт 420 орчим автомашин хог хаягдлыг цэвэрлэсэн.</p> <p>2. "Модыг Мод(а) болгоё-Ажилтан бүр нэг мод" аяныг 2023 оны 05-р сард болон 10-р сард Төрийн банкны нийт ажилтнуудын дунд өрнүүлж, 34 нэр төрлийн 6,586 ширхэг мод тарьсан.</p> <p>3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан цахим ухаалаг хэрэглээг тэгш хүртээмжтэй болгох, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхэд чиглэсэн "ABILITY EXPO 2023" арга хэмжээнд оролцож 300 гаруй хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд банкны бүтээгдэхүүн үйлчилгээг үзүүлж 14,000 гаруй иргэдэд мэдээлэл зөвлөгөө өгч ажилласан.</p> <p>Дэлгэрэнгүйг Төрийн банкны Тогтвортой хөгжлийн тайлангийн 25-р хуудаснаас үзнэ үү.</p>		GRI 413, SDG 8
S6.1	Тогтвортой өртгийн сүлжээний менежмент	Худалдан авалтын бодлого, журам	Танай компанийд дотоодын худалдан авалт болон тогтвортой буюу байгаль орчин, нийгмийн эрсдэл боломжыг хангасан худалдан авалтын бодлого, журам бий юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэсэн)?	2. Үгүй	1. Тийм		<p>2023 онд шинээр гаргасан "Тогтвортой хөгжлийн журам"-ын дотоод үйл ажиллагаа хэсэгт худалдан авалттай холбоотой, ногоон худалдан авалтыг дэмжих талаар заалт тусган мөрдөн ажиллаж байна.</p> <p>Банкны худалдан авалттай холбоотой холбогдох журамд энэ талаар нэмэлт зохицуулалт тусгахаар ажиллаж байна.</p>	-	GRI 204, SDG 8

S6.2		Дотоодын худалдан авалт	Дотоодын ханган нийлүүлэгчдээс авсан худалдан авалтын хувь	52	70	%	2023 оны хувьд 70%-ийг дотоодын бэлтгэн нийлүүлэгчдээс сонгосон байна. Нийт 114 гүйцэтгэгч болон бэлтгэн нийлүүлэгчээс 80 нь дотоодын байгууллага байна.	GRI 204, SDG 8
S6.3		Тогтвортой, ногоон худалдан авалт	Нийт ханган нийлүүлэгчдийн тоонд тогтвортой буюу байгаль орчин, нийгмийн шалгуураар сонгогдсон ханган нийлүүлэгчдийн хувь	-	6	%	2023 онд нийт худалдан авалтын 6%-д тогтвортой худалдан авах ажиллагааны шалгуур үзүүлэлт тавигдаж, худалдан авалтын ўйл ажиллагаа хийгдсэн.	-
G	Засаглалын шалгуур үзүүлэлтүүд							
G1.1	Авиалгал болон ёс зүй	Авиалга, хээл хахуулийн эсрэг бодлого журам	Авиалгын эсрэг эсвэл ёс зүйн бодлого, журам бий юу?	1. Тийм	1. Тийм		<p>Төрийн банкны ТУЗ-ийн тсгтоолоор батлагдсан "Төрийн банк хувьцаат компанийн дүрэм", "Дотоод ашиглан, залилангийн эрсдэлийн удирдлагын бодлого", Гүйцэтгэх захирлын тушаалаар батлагдсан "Төрийн банкны ёс зүйн зөвлөлийн ажиллах журам", "Хөдөлмөрийн дотоод журам", "Харилцагч, хувьцаа эзэмшигчийн эрх ашгийг хамгаалах ўйл ажиллагааны журам" болон "Төрийн банкны дотоод ашиглан, залилангийн эрсдэлийн удирдлагын журам"-ыг мөрдэж ажилладаг.</p> <p>2023 онд "Төрийн банк" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ажиллах журмыг баталсан бөгөөд тус журамд ТУЗ-ийн гишүүдийн ёс зүй, баримтлах зарчмыг тусган ТУЗ-өөс баталж буй бодлого, журмуудад ёс зүй, авлигын эсрэг зүйл, заалтуудыг тусган баталж байна.</p> <p><a href="#">Бодлого, журмын линк</a></p>	GRI 205, SDG 16

G2.1		Удирдах зөвлөлийн хараат бус байдал	Удирдах зөвлөлд хараат бус гишүүдийн суудлын хувь	33	33	%	"Төрийн банк" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн эзлжит бус хурлын 2024 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 05 дугаар шийдвэрээр "Төрийн банк" ХК-ийн дүрэмд өөрчлөлт оруулж, улмаар банкны ТҮЗ-ийн 9 гишүүний 4 нь хараат бус гишүүн байна гэж заасан.  <a href="#">Дурмийн линк</a>		GRI 102, OECD Principles of Corporate Governance, SDG 16
G2.2	Компанийн засаглал	Цөөнх, жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх	Цөөнх, жижиг хувьцаа эзэмшигчдийн эрхийг хамгаалах дүрэм, журам бий юу?	1. Тийм	1. Тийм		"Төрийн банк" хувьцаат компанийн дүрэм, "Төрийн банк" ХК-ийн Хяналтын зөвлөлийн ажиллах журам болон "Төрийн банк" ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын журмын дагуу зохицуулагдана.  <a href="#">Линк</a>		GRI 102, OECD Principles of Corporate Governance, SDG 16
G2.3		Компанийн засаглалын бодлого, журам	Компанийн засаглалын бодлого, журам бий юу?	1. Тийм	1. Тийм		Төрийн банкны "Зохистой засаглалын журам"-ыг батлан хэрэгжүүлэн ажиллаж байна. "Төрийн банк" ХК-ийн "өлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Засаглалын албаны ажиллах журам"-ыг батлан ТҮЗ-ийн дэргэд Засаглалын албыг байгуулан ажиллаж байна.  <a href="#">Журмын линк</a>		GRI 102, OECD Principles of Corporate Governance, SDG 16
G3.1		Комплаенсийн бодлого	Комплаенсийн бодлого, журам бий юу?	1. Тийм	1. Тийм		"Төрийн банк" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан Комплаенсийн бодлоготой.  <a href="#">Бодлогын линк</a>		GRI 102, OECD Principles of Corporate Governance, SDG 16
G3.2	Комплаенс	Комплаенсийн хөтөлбөр	Комплаенсийн хөтөлбөр, журам (ажилчдын сургалт, аудит, хяналтын систем, зөрчлийн талаар мэдээлэх, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх удирдамж, хориг гэх мэт) бий юу?	1. Тийм	1. Тийм		Комплаенсийн үйл ажиллагааны журам болон Төрийн банкны мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын хөтөлбөртэй.		GRI 102, OECD Principles of Corporate Governance, SDG 16

FS	Нэмэлт салбарын шалгуур үзүүлэлтүүд (Танай компанид хамаарах салбарын асуултуудыг бөглөнө үү)								
FS1		Санхүүгийн хүртээмж	Санхүүгийн мэдлэг дээшлүүлэх болон санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах санаачилга, арга хэмжээнд оролцсон хүмүүсийн тоо, жилээр	6,453	102,332	xүн	Санхүүч тагтаа хөтөлбөр, хуримтлалын өдөр болон харилцагчийн өдөрлөг, Инкубатор төвийн "Сургах үйлчилгээ", Оюутан, сурагчдад "Санхүүгийн боловсрол олгох" зэрэг арга хэмжээний хүрээнд 2023 онд нийт 102,332 иргэнд санхүүгийн зөвлөгөө, мэдээлэл хүргэн ажилласан.		SDG 1
FS2	Санхүүгийн үйлчилгээ	БОНЗ-ын эрсдэлийн менежмент	БОНЗ-ын эрсдэлийн шалгуур болон хориотой үйл ажиллагааны жагсаалтаар үнэлсэн гүйлгээний хувь	5.67	2.9	%	Тайлант онд зээлийн дүнгээр нийт багцын 2.9% буюу 34.6 тэрбум төгрөгийн 78 зээлийн хүсэлтэд БОНЗ-ын үнэлгээг хийж ажиллаа. Банк 100 сая төгрөгөөс дээш дүнтэй, 12 сараас дээш хугацаатай бизнесийн болон төслийн зээлүүдэд БОНЗ-н үнэлгээ хийдэг.		Mongolian Sustainable Finance Principles
FS3		Тогтвортой санхүүжилт	Нийт зээлийн багцад эзлэх ногоон/ ТХЗ таксономийн ангилалд нийцсэн ногоон/тогтвортой зээлийн эзлэх хувь	1.23	1.1	%	Тус үзүүлэлт 2022 онд 1.23% байсан бөгөөд 2023 онд 1.1% болсон, нийт зээлийн багц өмнөх оноос 22% -иар өссөн.		SDG 13, Mongolia Green Taxonomy

### ТӨРИЙН БАНК